



Аудитын код: САГ-2017/22/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261740 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитор Б.Баярмаа

Утас: 260512 Цахим хаяг: bayarmaab@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	8
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	9
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	9
2.9.1	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар	9
2.9.2	Дотоод хяналтын талаар	10
2.9.3	Сонгуулийн зардлын талаар	10
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10.1	Сонгуулийн санал тоолох машин, програм хангамжийн ашиглалтын талаар	11
2.10.2	Сонгуулийн зардлын бүртгэлийн талаар	11
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	11
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	11
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	11
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	13
3.1	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар	14
3.2	Дотоод хяналтын талаар	15
3.3	Сонгуулийн зардлын талаар	16
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	17
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	17
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	18
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21

1 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 04. 25 № 771

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ДАРГА Ч.СОДНОМЦЭРЭН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сонгуулийн ерөнхий хорооны дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Зөрчилгүй санал дүгнэлт

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 14-нөөс 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 39 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сонгуулийн ерөнхий хорооны үндсэн зорилго нь Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгууль, Ард нийтийн санал асуулгыг бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах, сонгуулийн хороодыг нэгдсэн удирдлагаар хангах, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах явдал юм.

Сонгуулийн ерөнхий хороо нь дарга, нарийн бичгийн дарга, орон тооны бус 7 гишүүн, Ажлын албаны дарга, 13 ажилтан, СЕХ-ны дэргэдэх Мэдээлэл технологийн төвийн захирал, нягтлан бодогч, нярав, 12 инженерийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Тус хороо нь дараах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль;
- Ард нийтийн санал асуулгын тухай хууль;
- Улс төрийн намын тухай хууль;
- Иргэний бүртгэлийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Архивын тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- УИХ-ын 2016 оны 06, 10, 11, 27, 28, 31, 32 дугаар тогтоол зэрэг хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 15 горим, сорил гүйцэтгэв.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэх НББ-ийн бодлогын баримт бичгийг 2013 онд СЕХ-ны даргын тушаалаар батласныг мөрдөж байгаа боловч холбогдох хууль, тогтоомжид орсон өөрчлөлтийг нэмж тусгаагүй байна. Сонгуулийн ерөнхий хорооны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Acolous” програмаар боловсруулж, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэж үзэв.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сонгуулийн ерөнхий хороо нь бүтэц орон тоо, үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалж Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т заасны дагуу байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын нэгжийг ажиллуулаагүй боловч байгууллагын өдөр тутмын ажилд ажлын албаны дарга, хорооны дарга нар хяналт тавин ажиллаж байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсөвт 2016 онд нийт 31,017.6 сая төгрөг батлагдсан бөгөөд тайлант онд Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулагдсантай холбоотойгоор сонгуулийн зардалд 28,912.3 сая төгрөг, Улс төрийн намуудад олгох дэмжлэг¹ болон бусад урсгал шилжүүлэгт 1,374.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны урсгал зардалд 731.3 сая төгрөг тус тус төлөвлөгдсөн байна.

Тайлант хугацаанд батлагдсан төсвөөс 31,011.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдож 0.02%-иар буюу 5.7 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Үүнээс гүйцэтгэлээр УИХ-ын болон аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах зардалд 26,682.7 сая төгрөг, Улс төрийн намуудад олгох дэмжлэг болон бусад урсгал шилжүүлгийн зардалд 1,219.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны урсгал зардалд 692.7 сая төгрөг, нийт 28,594.6 сая төгрөгийг зарцуулж, 2,417.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, батлагдсан төсвийг 7.8%-иар хэмнэж ажилласан байна. Төсвийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Батлагдсан төсөв, зардлын гүйцэтгэлийг харьцуулж харуулбал:

д/д	Зардал	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Хэмнэлт /сая.төг/
1	Сонгуулийн зардал	28,912.3	26,682.7	2,229.6
2	Намуудад олгох дэмжлэг	1,374.0	1,219.2	154.8
3	Үндсэн ү/а-ны урсгал зардал	731.3	692.7	38.6
	Дүн	31,017.6	28,594.6	2,423.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, орлого, зарлага зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Тайлант хугацаанд УИХ-ын болон аймаг, нийслэл сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн зардалд нийт 28,912.3 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 92.3% буюу 26,682.7 сая төгрөг зарцуулсан байна. Үүнийг сонгууль тус бүрээр харуулбал:

¹ Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналыг нийт хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр тооцож, сонгуулийн дүн гарсны дараа гурван сарын дотор багтаан Улсын Их Хуралд суудал бүхий намд төр нэг удаа мөнгөн дэмжлэг үзүүлнэ.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

д/д	Зардал	Төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /+,-/ /сая.төг/
1	УИХ-ын болон Аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгууль	14,953.9	14,516.5	437.4
2	Сум дүүргийн ИТХ-ийн сонгууль	13,958.4	12,166.2	1,792.2
	Дүн	28,912.3	26,682.7	2,229.6

ҮАГ-аас дээрх сонгуулийн зардлуудад Гүйцэтгэлийн аудитын газраас 2016 оны Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн зардлын гүйцэтгэлд, Нийцлийн аудитын газраас Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэлд тус тус аудит хийж дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.

Дээрх зөрчлүүдэд Орон нутгийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар аймаг, нийслэлийн төрийн аудитын байгууллагаас 2.2 сая төгрөгийн зөрчилд 4 акт тогтоож, 86.5 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлсэн байна.

СЕХ-ны даргын төсвийн үндсэн үйл ажиллагааны урсгал зардалд 731.3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 94.7% буюу 692.7 сая төгрөгийг зарцуулж, 38.6 сая төгрөгийг хэмнэсэн байна. Урсгал зардлыг, төсөвтэй харьцуулж харуулбал:

д/д	Зардлын ангилал	Төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү /+,-/ /сая.төг/
1	Цалин хөлс	444.7	417.1	27.6
2	НДШ	48.9	45.9	3.0
3	Байрны түрээс	15.4	13.7	1.7
4	Хангамжийн материал	40.6	37.9	2.7
5	Томилолт, зочны зардал	4.7	2.6	2.1
6	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	177.0	175.5	1.5
	Дүн	731.3	692.7	38.6

- Урсгал шилжүүлгээр нийт 1,219.2 сая төгрөгийг зарцуулснаас Улс төрийн намд үзүүлэх дэмжлэгт 1,215.5 сая төгрөг, Азийн сонгуулийн байгууллагын гишүүнчлэлийн төлбөрт 2.5 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулалд 1.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- 2016 оны эхэнд СЕХ-ны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,474.2 сая төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 151.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, эргэлтийн бус хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлыг тооцсоноор жилийн эцэст 576.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт үндсэн хөрөнгийн 5.8%-ийг авто тээврийн хэрэгсэл, 27.4% -ийг компьютер тоног төхөөрөмж, 21.6% -ийг тавилга хэрэгсэл, 45.2%-ийг програм хангамж эзэлж байна. Тайлант хугацаанд 2,049.2 сая төгрөгийн элэгдлийн зардал тайлагнасан нь биет хөрөнгөнд бүртгэлтэй 11,401.1 сая төгрөгийн үнэ бүхий 2500 ширхэг санал тоолох машин, биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 2,542.7 сая төгрөгийн Электрон дамжуулалтын системийн програм, ICP-д суулгах EED програм зэрэгт тооцогдох элэгдлийн зардал өндөр байгаатай холбоотой байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны “Журам батлах тухай” 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Сонгуулийн ерөнхий хорооны даргын шилэн дансны нэгдсэн сайтад дараах мэдээлэл оруулсан байна.

- “Төсөв” цэсний Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, Дараа жилийн төсвийн төсөл, Санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг тус тус 1 удаа;
- “Төсөв” цэсний Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн мэдээг тус тус 12 удаа;
- “Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт” цэсэнд МУ-ын 2016 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүй тул хамааралтай мэдээлэл байхгүй;
- “Бусад” цэсний Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл....төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт хорооны даргын хөрөнгөтэй холбоотой захирамжийг сар бүр мэдээлж ажилласан байна.

Мөн СЕХ-ны даргад шууд харьяалах СЕХ, түүний дэргэдэх Мэдээлэл технологийн төв шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих мэдээллүүдийг цаг хугацаанд нь байршуулж ажилласан байна.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Сонгуулийн ерөнхий хороотой холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 12 дансанд эрсдэлийн үнэлгээ хийж, үүнээс 4 дансанд эрсдэлтэй гэж үзэн батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт 15 нарийвчилсан горим сорил гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд гарсан зардлуудаас 715 гүйлгээний нийт 28,578.6 сая төгрөгийн гүйлгээг түүвэрлэн үзэхэд зөрчилтэй гүйлгээ гараагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг хангаж байна.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл технологийн төвийн үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо машин тоног төхөөрөмжийн ашиглах хугацааг 4-5 жилээр, програм хангамжийг 3-5 жилээр тооцож элэгдэл байгуулсан байна. СЕХ-ний Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн элэгдлийг хэдэн жилийн хугацаагаар тооцох талаар тусгайлан заагаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт биет болон биет бус хөрөнгөнд элэгдэл тооцох талаар баримтлах бодлогыг тодорхой тусгуулах, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох

хууль, журманд орсон өөрчлөлтийг тусгаж сайжруулахаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.2 Дотоод хяналтын талаар

Байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1 “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сонгуулийн ерөнхий хорооны бүтэц, орон тоо, үйл ажиллагааны цар хүрээнд тохирсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.3 Сонгуулийн зардлын талаар

Сонгуулийн зардалд хийсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар дараах зөрчлүүд илэрчээ. Үүнд:

Монгол УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийн зардалд хийсэн аудитаар:

- Сонгуулийн автоматжуулсан системийг хэрэглэхтэй холбоотой зарим тоног төхөөрөмжийг төлөвлөснөөс 4.2-13.2 хүртэл сая төгрөгийн өндөр үнээр худалдан авсан;
- Сонгуульд ажиллах ажилтны мэдээллийн сан бүрдүүлэх програм шинээр боловсруулан, түүнийг аймаг, нийслэл, дүүргийн төрийн сангийн сүлжээтэй холбоход техникийн нөхцөл бүрдээгүйгээс төлөвлөгөөнд тусгагдаагүй 10.5 сая төгрөгийн зардал гаргасан;

Орон нутгийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар:

- Зарим аймгууд дээд шатны сонгуулийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр батлагдсан төсвөөс 11.4 сая төгрөгийг зориулалт бус зүйлд зарцуулж, хөрөнгө бэлтгэж түүнийгээ холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгуулаагүй;
- Батлагдсан төсвөөс 52.3 сая төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан;
- Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй, хүчин төгөлдөр бус баримтаар 84.2 сая төгрөгийн зардал гаргасан;
- Нийслэлийн зарим дүүргийн сонгуулийн хороо анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар нийт 7.5 сая төгрөгийн гүйлгээ хийж, 3,3 сая төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан, 1.0 сая төгрөгийг илүү олгосон,
- Зарим аймгийн сонгуулийн хороо 20.7 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, 0.3 сая төгрөгийг зориулалт бусаар, 3.8 сая төгрөгийн илүү олгосон зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.6, СЕХ-ны 2016 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.1 гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц дараах асуудал ажиглагдлаа.

2.10.1 Сонгуулийн санал тоолох машин, програм хангамжийн ашиглалтын талаар

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй сонгуулийн санал тоолох машин болон програм хангамжийн ашиглах хугацааг 5 хүртэл жилээр байгуулснаас 2017 онд элэгдлийн зардлаараа өртгөө бүрэн нөхөж дуусахаар байна. Уг санал тоолох машин болон програм хангамж нь цаашид ашиглагдах боломжтой байгааг харгалзан үзэж ашиглалтын хугацааг тогтоох, хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2.10.2 Сонгуулийн зардлын бүртгэлийн талаар

Сонгууль зохион байгуулагдсан жилд төсвөөс олгосон санхүүжилтийг СЕХ-ноос аймаг, нийслэл, сум дүүргийн сонгуулийн хороонд хуваарилан шууд зардлаар бүртгэж байна. Цаашид сонгууль зохион байгуулагдах жилүүдэд түүнтэй холбогдон гарах зардлыг хэрхэн бүртгэж тайлагнах талаар анхаарч үзэх шаардлага гарч байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар СЕХ-ний НБББББ-т үндсэн хөрөнгийн элэгдлийг хэдэн жилийн хугацаагаар тооцох талаар тусгайлан заагаагүй, нэмэлт өөрчлөлт хийгээгүй, байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй, сонгуульд зориулсан зарим зардлыг холбогдох эрх зүйн актын дагуу зарцуулаагүй зэрэг материаллаг бус зөрчлүүд илэрлээ.

Эдгээр зөрчлийг асуудлын бүртгэлд нэгтгэж, баталгаажуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас итгэл үзүүлж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч “Итгэмжлэл” гардуулсан байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувь 653.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан болно.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Үндсэн хөрөнгийн элэгдлийн ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл технологийн төвийн үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо машин тоног төхөөрөмжийн ашиглах хугацааг 4-5 жилээр, програм хангамжийг 3-5 жилээр тооцож элэгдэл байгуулсан байна. Сонгуулийн ерөнхий хорооны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн элэгдлийг хэдэн жилийн хугацаагаар тооцох талаар тусгайлан заагаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтын дагуу байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт биет болон биет бус хөрөнгөнд элэгдэл тооцох хугацаа, сонгуультай холбоотой гарсан зардал зэргийг бүртгэхэд баримтлах бодлогыг тусгаж, сайжруулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Зардал өндөр гарах, Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан.

3.2 Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сонгуулийн ерөнхий хорооны бүтэц орон тоо, үйл ажиллагааны цар хүрээнд тохирсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, Төсвийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах,

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Хууль, дүрэм, журмыг зөрчих, санхүүгийн сахилга бат алдагдах.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан.

3.3 СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

МУИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийн зардалд хийсэн аудитаар:

Сонгуулийн автоматжуулсан системийг хэрэглэхтэй холбоотой зарим тоног төхөөрөмжийг төлөвлөснөөс өндөр үнээр худалдан авсан;

Сонгуульд ажиллах ажилтны мэдээллийн сан бүрдүүлэх програм шинээр боловсруулан, түүнийг аймаг, нийслэл, дүүргийн төрийн сангийн сүлжээтэй холбоход техникийн нөхцөл бүрдээгүйгээс төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал гаргасан;

Орон нутгийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар:

Зарим аймгууд дээд шатны сонгуулийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр батлагдсан төсвөөс зориулалт бус зүйлд зарцуулж, хөрөнгө бэлтгэж түүнийгээ холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар зардал гаргасан, зориулалт бусаар зарцуулсан, илүү олгосон, зардал хооронд гүйлгэн зарцуулсан;

Нийслэлийн зарим дүүргийн сонгуулийн хороо анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж, зардал хооронд гүйлгэн зарцуулсан, илүү олгосон зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.6 улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих; СЕХ-ны 2016 оны 3 дугаар сарын 2-ны 4 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.1. Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтлөнө” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Хууль, дүрэм, журмыг зөрчих.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	/мян. төг/	
	2015 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	138,283.8	359,650.8
БАРАА МАТЕРИАЛ	138,283.8	359,650.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,474,223.2	576,682.2
Биет хөрөнгө	1,705,515.1	315,791.7
Биет бус хөрөнгө	768,708.0	260,890.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,612,507.0	936,333.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ	2,612,507.0	936,333.0
Засгийн газрын хувь оролцоо	2,612,507.0	936,333.0
Засгийн газрын сан	14,410,826.1	14,410,826.1
Хуримтлагдсан үр дүн	-11,799,530.6	-13,475,704.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,211.5	1,211.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,612,507.0	936,333.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,612,507.0	936,333.0

4.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

Үзүүлэлт	2015 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	854,222.9	31,011,853.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	904.0	0.5
Нийтлэг татварын бус орлого	904.0	0.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	853,318.9	31,011,853.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	4,363,866.9	32,688,027.8
УРСГАЛ ЗАРДАЛ	4,363,866.9	32,688,027.8
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,235,760.1	29,051,521.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	421,109.3	417,146.5
Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,421.6	45,885.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,014.0	13,690.0
Хангамж бараа материалын зардал	46,332.4	50,419.2
Томилолт, зочны зардал	36,207.0	2,556.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	157,603.4	175,453.4
Бараа үйлчилгээний бусад зардал	3,505,072.4	28,346,370.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,106.9	3,636,506.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-3,509,644.0	-1,676,173.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-3,509,644.0	-1,676,173.9

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Цөөнхийн хувь оролцоо	Засгийн газрын хувь оролцоо
2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,122,151.0	-	6,122,151.0
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт	725.6	-	725.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,122,876.5	-	6,122,876.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-725.6	-	-725.6
Тайлант үеийн үр дүн	-3,509,644.0	-	-3,509,644.0
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,612,507.0	-	2,612,507.0
2016 оны 1 дүгээр сарын 1-ээрх үлдэгдэл	2,612,507.0	-	2,612,507.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,612,507.0	-	2,612,507.0
Тайлант үеийн үр дүн	-1,676,173.9	-	-1,676,173.9
2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	936,333.0	-	936,333.0

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

Үзүүлэлт	2015 оны 12 сарын 31	2016 оны 12 сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	853,318.9	31,011,853.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	0.5
Нийтлэг татварын бус орлого	0.0	0.5
ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	853,318.9	31,011,853.4
Улсын төсвөөс санхүүжих	853,318.9	31,011,853.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	853,323.4	31,011,853.9
УРСГАЛ ЗАРДАЛ	853,323.4	31,011,853.9
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	725,216.6	27,375,347.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	421,109.3	417,146.5
АО-с НД-д төлөх шимтгэл	44,421.6	45,885.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,014.0	13,690.0
Хангамж бараа материалын зардал	40,802.8	37,906.3
Томилолт, зочны зардал	36,265.5	2,556.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	157,603.4	175,453.4
Бараа, үйлчилгээний бусад зардал	0.0	26,682,709.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,106.9	3,636,506.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-4.5	0.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	-4.5	0.0

4.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I.НИЙТ ЗАРЛАГА БА ЗЭЭЛИЙН ДҮН	31,017,648.4	28,594,576.1	2,423,072.3	92.2
II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	31,017,648.4	28,594,576.1	2,423,072.3	92.2
IV.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	31,017,648.4	28,594,576.1	2,423,072.3	92.2
Бараа, үйлчилгээний зардал	29,643,652.5	27,375,347.9	2,268,304.6	92.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	444,737.9	417,146.5	27,591.4	93.8
Үндсэн цалин	419,327.9	393,433.9	25,894.0	93.8
Унаа хоолны хөнгөлөлт	25,410.0	23,712.6	1,697.4	93.3
АО-оос НД-д төлөх шимтгэл	48,921.1	45,885.9	3,035.2	93.8
Тэтгэврийн даатгал /7%/	31,131.7	29,200.1	1,931.6	93.8
Тэтгэмжийн даатгал /0.8%/	3,558.0	3,337.2	220.8	93.8
ҮОМШ өвчний даатгал /1%/	4,447.3	4,171.4	275.9	93.8
Ажилгүйдлийн даатгал /0.2%/	889.4	834.3	55.1	93.8
Байгууллага төлөх ЭМД /2%/	8,894.7	8,342.9	551.8	93.8
Байр ашиглалтын зардал	15,410.3	13,690.0	1,720.3	88.8
Байрны түрээс	15,410.3	13,690.0	1,720.3	88.8
Хангамж, бараа материалын зардал	40,569.9	37,906.3	2,663.6	93.4
Бичиг хэрэг	7,339.5	6,333.7	1,005.8	86.3
Тээвэр шатахуун	18,421.1	18,130.7	290.4	98.4
Шуудан холбоо	13,525.6	12,283.0	1,242.6	90.8
Ном, хэвлэл авах	0.0	77.0	-77.0	0
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл хялдалдан авах	1,283.7	1,082.0	201.7	84.3
Томилолт зочны зардал	4,744.2	2,556.7	2,187.5	53.9
Дотоод томилолт	4,744.2	2,556.7	2,187.5	53.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	176,989.7	175,453.4	1,536.3	99.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,823.0	171,427.5	1,395.5	99.2
Даатгалын үйлчилгээ	1,646.0	1,603.4	42.6	97.4
Тээврийн хэрэгслийн татвар	201.0	180.0	21.0	89.6
Тээврийн хэрэгслийн оношилгоо	33.0	33.0	0.0	100
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,226.7	2,149.5	77.2	96.5
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ	60.0	60.0	0.0	100
Бараа, үйлчилгээний бусад зардал	28,912,279.4	26,682,709.0	2,229,570.4	92.29
Бараа үйлчилгээний бусад зардал	28,912,279.4	26,682,709.0	2,229,570.4	92.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,373,995.9	1,219,228.2	154,767.7	88.7
ЗГ-ын урсгал шилжүүлэг	1,367,265.9	1,218,010.0	149,255.9	89.1
ЗГ-ын гадаад шилжүүлэг	2,660.0	2,489.0	171.0	93.6
ЗГ-ын дотоод шилжүүлэг	1,364,605.9	1,215,521.0	149,084.9	89.1

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Бусад урсгал шилжүүлэг	6,730.0	1,218.2	5,511.8	18.1
АО-с олгох бусад тэтгэмж, урамшил	6,730.0	1,218.2	5,511.8	18.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,017,648.4	28,594,576.1	2,423,072.3	92.2
Төсвөөс санхүүжих	31,017,648.4	28,594,576.1	2,423,072.3	92.2
Мөнгөн хөрөнгийн эхний үйлдэгдэл	0.0	0.0	0.0	0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.0	0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0		
АЖИЛЛАГСАД БҮГД	30.0	30.0		
Удирдах ажилтан	4.0	4.0		
Гүйцэтгэх ажилтан	26	26		